



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/122/СТА/ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2020 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: nbunchin0719@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

᠒᠐᠒᠐.᠐᠒.᠒᠓ № 1/᠒14

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ ᠓

Г ЖИНСТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА С.УРАНГОО
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020166

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2.1. Оршил

Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Жинст сумын Эрүүл мэндийн төвийн дарга С.Урангоо танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.о.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дүгээр сарын 15-наас 2020 оны 02 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дах Төрийн аудитын аудитор Н.Бүнчинсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дах Төрийн аудитын газар 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 87 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Жинст сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Бид чадварлаг, бүтээлч, ёс зүйтэй хамт олныг бүрдүүлж, үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэж, ард иргэдэд эрүүл зан үйлийг төлөвшүүлэн дадал хандлагыг нь өөрчлөн өвчлөл эндэгдлийг бууруулахад оршино”

Жинст сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн эрүүл мэнд-Амбулатори
- Хэвтэн эмчлүүлэх
- Оношилгоо
- Дэмжих үйлчилгээ

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Жинст сумын Эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Жинст сумын Эрүүл мэндийн төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Жинст сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Жинст сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 31 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшин “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 394554.5 мянган төгрөгөөс тооцон 7891.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6283.2 мянган төгрөгөөр буюу 1 хувиар өссөн

байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	14697.2	16879.4	2182.2
Үндсэн хөрөнгө	720489.3	709770.2	-10719.2
Хуримтлагдсан элэгдэл	-134205.4	-119385.2	14820.2
Нийт хөрөнгө	600981.2	607264.3	6283.2
Өр төлбөр	199.5	199.5	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	600781.7	607064.8	6283.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	600981.2	607264.3	6283.2

Бараа материалын дансны үлдэгдэл 2182,2 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал 669,3 мянга, аж ахуйн материал 1458,1 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Аж ахуйн материал өссөн шалтгаан нь тооллогоор 2364,4 мянган төгрөгийн материал бүртгэлд тусгаагүй байсныг орлого авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10719,2 мянган төгрөгөөр буурсан тухайн тайлант хугацаанд 24937,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авсан, Жинст сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019.05.15-ны 13 дугаар тогтоолоор эхний хагас жилийн тооллого явуулж тооллогоор илэрсэн 6075,0 мянган төгрөгийг үндсэн хөрөнгөнд бүртгэж авсан, мөн Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 1 сарын 31-ний өдрийн 10 дугаар тогтоолоор авто тээврийн хэрэгслээс 10556,3 мянган төгрөг, барилга байгууламжаас 6693,6 мянган төгрөгийн гаршийг актлах шийдвэрийн дагуу хөрөнгөөс хассан, Жинст сумын ИТХ-ын 2019.05.15-ны өдрийн 12 дугаар тогтоолоор 22116,8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, буруу ангилж бүртгэсэн 2364,4 мянган төгрөгийн тавилга хэрэгслийг бараа материалд шилжүүлснээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэлд олон жил болсон эзэн холбогдогч нь тодорхойгүй байгаа тул даргад хариуцуулан барагдуулах зөвлөмжийг өгөв.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 607064,8 мянган төгрөг болж 6283,2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үеийн үр дүн 6283,2 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хөтөлбөрт зориулан 375267,4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 375267,4 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 328936,8 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 22134,6 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 24196,0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 327111,8 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 22026,9 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс, 23502,5 мянган төгрөгийн орон нутгийн төсвөөс тус тус санхүүжүүлсэн байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 372641,3 мянган төгрөг буюу 99,3 хувьтай байгаа ба 1825,0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн нь эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл 1420,2 мянга, цалин НДШ 623,0 мянган төгрөгийн зардлыг зарцуулаагүйтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Нэмэлт санхүүжилтийн дансанд орлого орж зарцуулагдаагүй байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 30 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 30 эрсдэл тодорхойлж нийт 32 горим сорил хэрэгжүүллээ.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 30 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 25 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Илрүүлэлт: Санхүүгийн үр дүнгийн тайланд нийгмийн даатгалын сангаас орж ирсэн тэтгэмжийн мөнгийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн зааврын 2.Орлого /Орлого хүлээн зөвшөөрөх, үнэлэх/ заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийх

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Аудитаар нийт 4479,8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 3240,0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал
(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	3240,0	
2	Төлбөрийн акт тогтоосон			
3	Албан шаардлага өгсөн			
	Дүн	1	3240,0	

Аудитаар илэрсэн 3240,0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Цалингийн нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг хуулийн дагуу олгож байгаа эсэх, төсвөөс сургалтын төлбөр төлсөн эсэх, бусад бараа үйлчилгээний зардлыг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Жинст сумын Эрүүл мэндийн төвийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 122 мэдээллийг хугацаанд нь, 26 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 3 мэдээллийг байршуулаагүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй /хугацаа болоогүй/
1	Бүтэн жил	11	11	4	3	3
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	2	2	
4	Сар бүр	3	36	31	5	
5	Тухай бүр	8	96	81	15	
6	Нийт	27	151	122	26	3

Бүтэн жилээр байршуулах 11 мэдээллээс хугацаандаа 4, хугацаа хоцроосон 4, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Үүнээс хугацаа хоцроосон 4 мэдээлэл нь байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлсийн жагсаалт, гүйцэтгэл байна. Хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Энэ нь санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт байна.

Улирал бүр байршуулах 4 мэдээллээс 2 мэдээлэл хоцроосон, Тухай бүр байршуулах 96 мэдээллээс 15 мэдээлэл хугацаа хоцроосон байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Жинст сумын Эрүүл мэндийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Жинст сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Жинст сумын Хөнөг багийн бага эмч дутагдалтай байгаатай холбогдуулан бага эмчийн мэргэжлээр суралцуулах зорилгоор 2018 оны 09 сарын 20-ны өдөр байгууллагын захиалгаар боловсон хүчин бэлтгэх гурван талт гэрээг иргэн Д.Сүгжамаатай байгуулсан байна. Уг гэрээнд орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр сургалтын төлбөрийг санхүүжүүлэхээр заасан байхад сумын Эрүүл мэндийн төвийн төсөвт сургалтын зардлыг батлаагүй байхад байгууллагын төсөл хөтөлбөрийн данснаас 2.2 сая төгрөгийг төлсөн байна.

Мөн Их эмч Э.Болортуяаг ЭХО-ны сургалтад суралцуулах зорилгоор гурван талт гэрээ байгуулан, гэрээнд цалин болон тэтгэмжийн зардлыг орон нутгийн төсвөөс хариуцах талаар заасан байна. Гэтэл үндсэн цалинг гэрээний дагуу олгож байгаа байхад төсөл хөтөлбөрийн зардлаас сургалтын зардалд 261.0 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т " Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна

1.2. Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх, төсөв үр ашиггүй зарцуулагдах шамшигдах

1.3. Өгсөн зөвлөмж:

Бараа үйлчилгээний зардлын төсөл хөтөлбөрийн зардлыг зориулалтын дагуу зарцуулж, төсөвт сургалтын зардал батлагдаагүй байхад санхүүжүүлдэг явдлыг таслан зогсоох.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

2.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн явцын аудитаар сахилгын шийтгэлтэй Ж.Нохойхүү Г.Нарантуяа, Ж.Буян нарт 579,5 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон зөрчил илэрсэн ба 12 дугаар сарын цалингаас суутган тооцсон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 хавсралтын “Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.7 “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын мөнгөн урамшуулал олгохгүй” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2. Эрсдэл:

Батлагдсан дүрэм журмыг мөрдөж ажиллахгүй байх

2.3. Өгсөн зөвлөмж:

Ажиллагсад үр дүнгийн урамшуулал олгохдоо сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагч нарт олгодог явдлыг таслан зогсоож, Засгийн газрын 2019 оны 05 тоот тогтоолыг мөрдөж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

3. Балансын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Оны эхэнд авлага байхгүй ба тайлант хугацаанд шинээр нэмж үүсээгүй байна. Өглөг оны эхэнд 199,5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант хугацаанд барагдаагүй үлдэгдэлтэй байна. Эзэн холбогдогч нь байхгүй олон жил болсон өглөг байна.

3.2. Эрсдэл:

Санхүүгийн тайланд тусгагдсан авлага, өглөг буруу илэрхийлэгдэх

3.3. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланд тусгагдсан авлага, өглөгийн эзэн холбогдогчийг тогтоож авлага, өглөгийг хариуцан барагдуулахыг төсвийн менежерт даалгаж цаашид Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

4. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

4.1. Илрүүлэлт:

Тус байгууллага нь төсвийн хөрөнгөөр цалингийн программыг 2019 оны 8 сард худалдан авсан боловч тайлант онд ашиглаагүй байна

3.2. Эрсдэл

Цалин, НДШ, ХАОАТ илүү дутуу тооцогдох

4.3. Өгсөн зөвлөмж:

Ажиллагсдын цалин, хөлсийг цалингийн программ ашиглан гүйцэтгэн нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг иж бүрэн санхүүгийн программаар үнэн зөв тайлагнах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>14,697,202.99</u>	<u>16,879,386.99</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	14,697,202.99	16,879,386.99
351	Түүхий эд материал	1,764,565.00	2,433,869.00
35110	Тусгай зориулалттай материал	1,216,096.00	1,216,096.00
35130	Эм боох материал	548,469.00	1,217,773.00
354	Хангамжийн материал	12,932,637.99	14,445,517.99
35420	Аж ахуйн материал	2,501,500.00	3,959,580.00
35460	Хүнсний материал	00.00	54,800.00
35470	Бусад хангамжийн материал	10,431,137.99	10,431,137.99
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>586,283,985.40</u>	<u>590,384,962.91</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	586,283,985.40	590,384,962.91
392	Биет хөрөнгө	583,355,985.40	587,255,296.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	542,584,082.86	535,890,482.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	-11,266,075.55	-14,935,545.83
39203	Авто-тээврийн хэрэгсэл	50,328,862.00	39,772,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-21,916,528.84	-18,048,250.32
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	74,856,002.28	94,524,156.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	-65,915,172.89	-66,749,889.81
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,044,693.34	28,639,945.02
39208	Хуримтлагдсан элэгдэл	-26,359,877.80	-11,838,101.94
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,297,696.91	7,345,070.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,297,696.91	-7,345,070.00
393	Биет бус хөрөнгө	2,928,000.00	3,129,666.65
39301	Програм хангамж	450,000.00	670,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-468,333.35
39303	Бусад биет бус хөрөнгө	2,928,000.00	2,928,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>600,981,188.39</u>	<u>607,264,349.90</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>199,500.00</u>	<u>199,500.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	199,500.00	199,500.00
413	Өглөг	199,500.00	199,500.00
4136	Бусад өглөг	199,500.00	199,500.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	199,500.00	199,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>600,781,688.39</u>	<u>607,064,849.90</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	600,781,688.39	607,064,849.90
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	295,911,043.12	295,911,043.12
51101	Өмч: - төрийн	295,911,043.12	295,911,043.12
512	Хуримтлагдсан үр дүн	-70,436,433.54	-64,153,272.03
51210	Өмнөх үеийн үр дүн	-70,436,433.54	-70,436,433.54
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	6,283,161.51
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	375,307,078.81	375,307,078.81
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>600,981,188.39</u>	<u>607,264,349.90</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	335,470,142.00	399,599,129.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,077,520.00	24,439,409.10
120	Нийтлэг татварын бус орлого	7,077,520.00	24,439,409.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,077,520.00	24,439,409.10
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,077,520.00	24,439,409.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	35,456,722.00	46,222,920.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	292,935,900.00	328,936,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	24,196,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	24,196,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	22,026,920.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	22,026,920.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	341,210,224.19	390,460,858.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	341,210,224.19	390,460,858.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	305,217,174.19	387,942,440.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	192,755,417.00	250,577,629.00
210101	Үндсэн цалин	192,755,417.00	250,577,629.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,492,550.00	31,032,914.00
210201	Тэтгэврийн даатгал	22,492,550.00	31,032,914.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,711,549.00	19,102,550.00
210301	Гэрэл, цахилгаан	2,096,721.00	2,281,734.00
210302	Түлш, халаалт	17,590,828.00	16,820,816.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,211,190.00	22,758,999.10
210401	Бичиг хэрэг	1,096,150.00	2,503,800.00
210402	Тээвэр, шатахуун	10,548,550.00	13,371,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	523,390.00	1,972,990.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,043,100.00	1,808,000.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	3,102,409.10
2105	Нормативт зардал	30,467,581.00	23,645,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,747,341.00	16,515,820.00
210502	Хоол, хүнс	5,796,140.00	7,129,280.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,213,580.00	3,935,000.00
210604	Урсгал засвар	2,213,580.00	3,935,000.00
2107	Томилолт, зочны зардал	949,000.00	1,814,000.00
210702	Дотоод албан томилолт	949,000.00	1,814,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,366,722.00	400,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,049,585.19	34,676,247.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,499,610.00	10,619,135.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,549,975.19	24,057,112.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,993,050.00	2,518,418.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	693,450.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	693,450.00

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	1,824,968.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,824,968.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-5,740,082.19	9,138,271.08
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,123,860.78	2,853,909.57
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	1,036,980.21
225003	Хөрөнгө оруулалтын гарз	00.00	1,816,929.36
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,123,860.78	-2,853,909.57
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-7,863,942.97	6,284,361.51

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	328,392,622.00	376,399,508.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	328,392,622.00	376,399,508.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	292,935,900.00	328,936,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	24,196,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	24,196,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	23,266,708.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	1,239,788.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	22,026,920.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	328,392,622.00	376,399,508.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	328,392,622.00	376,399,508.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	292,399,572.00	372,641,302.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	192,414,649.00	250,577,630.00
210101	Үндсэн цалин	143,422,749.00	189,378,030.00
210102	Нэмэгдэл	34,220,200.00	47,271,200.00
210104	Урамшуулал	14,771,700.00	13,928,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,673,318.00	31,032,913.00
210201	Тэтгэврийн даатгал	20,134,396.00	20,980,849.00
210202	Тэтгэмжийн даатгал	658,721.00	2,508,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	530,671.00	2,024,164.00
210204	Ажилгүйдлийн даатгал	134,241.00	501,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,215,289.00	5,017,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,711,549.00	19,102,550.00
210301	Гэрэл, цахилгаан	2,096,721.00	2,281,734.00
210302	Түлш, халаалт	17,590,828.00	16,820,816.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,498,890.00	19,973,390.00
210401	Бичиг хэрэг	1,118,150.00	2,628,800.00
210402	Тээвэр, шатахуун	10,548,550.00	13,371,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	523,390.00	1,972,990.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,308,800.00	1,999,800.00
2105	Нормативт зардал	23,961,664.00	26,815,714.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,918,624.00	18,183,634.00

210502	Хоол, хүнс	5,699,940.00	7,184,080.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,343,100.00	1,448,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,547,580.00	11,005,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,950,000.00	2,795,000.00
210602	Тавилга	00.00	3,810,000.00
210604	Урсгал засвар	8,597,580.00	4,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	949,000.00	1,814,000.00
210702	Дотоод албан томилолт	949,000.00	1,814,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	484,772.00	400,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,158,150.00	11,920,105.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,158,150.00	11,920,105.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,993,050.00	3,758,206.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,150,972.00	1,239,788.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	35,150,972.00	1,239,788.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	693,450.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	693,450.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	1,824,968.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,824,968.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	295,911,043.12	375,307,078.81	-70,436,433.54	600,781,688.39
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	295,911,043.12	375,307,078.81	-70,436,433.54	600,781,688.39
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00

D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	6,283,161.51	6,283,161.51
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	295,911,043.12	375,307,078.81	-64,153,272.03	607,064,849.90

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	375,267,400.00	372,641,302.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	375,267,400.00	372,641,302.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	375,267,400.00	372,641,302.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	250,874,300.00	250,577,630.00
210101	Үндсэн цалин	189,674,700.00	189,378,030.00
210102	Нэмэгдэл	47,271,200.00	47,271,200.00
210104	Урамшуулал	13,928,400.00	13,928,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,359,200.00	31,032,913.00
210201	Тэтгэврийн даатгал	21,324,300.00	20,980,849.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,508,700.00	2,508,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,007,000.00	2,024,164.00
210204	Ажилгүйдлийн даатгал	501,700.00	501,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,017,500.00	5,017,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,796,000.00	19,102,550.00
210301	Гэрэл, цахилгаан	2,214,900.00	2,281,734.00
210302	Түлш, халаалт	17,581,100.00	16,820,816.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,016,600.00	19,973,390.00
210401	Бичиг хэрэг	2,200,000.00	2,628,800.00
210402	Тээвэр, шатахуун	13,800,600.00	13,371,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,016,000.00	1,972,990.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	1,999,800.00
2105	Нормативт зардал	28,013,800.00	26,815,714.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,603,800.00	18,183,634.00
210502	Хоол, хүнс	6,900,000.00	7,184,080.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,510,000.00	1,448,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,005,000.00	11,005,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,505,000.00	2,795,000.00
210602	Тавилга	4,100,000.00	3,810,000.00
210604	Урсгал засвар	4,400,000.00	4,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,820,000.00	1,814,000.00
210702	Дотоод албан томилолт	1,820,000.00	1,814,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	400,000.00	400,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11982500.00	11920105.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,982,500.00	11,920,105.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	375,267,400.00	372,641,302.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	328,936,800.00	327,111,832.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	328,936,800.00	327,111,832.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	24,196,000.00	23,502,550.00
132001	Орон нутгийн төсвөөс	24,196,000.00	23,502,550.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,134,600.00	22,026,920.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	22,134,600.00	22,026,920.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22.00	22.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:  Н.БҮНЧИНСҮРЭН 2020.02.25

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЭНЯМ 2020.02.25

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ 2020.02.25

6117143544
БНА0067 9007423